



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/114

Булган сум

Утаат болон электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдах, худалдан борлуулахыг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, 6.7.14 дэх заалт, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд зах зээлд нийлүүлж байгаа бараа, ажил үйлчилгээ, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагууд 21 нас хүрээгүй хүнд утаат болон электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдаалах, 21 нас хүрээгүй хүнээр тамхи худалдан борлуулахыг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метр дотор утаат болон электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг тус тус хориглосугай.

2.Энэхүү захирамжийг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Холбогдох хууль тогтоомж болон захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг), Цагдаагийн газар (Л.Ганбаатар), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

